



УВС АЙМАГ
ДАВСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 91/29

Зүүнхөвөө

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд
зориулсан хөрөнгийг зарцуулах тухай

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2021 оны ажлын төлөвлөгөөг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Архигүй амьдралыг цогцлооё” аяны хүрээнд уралдаан тэмцээн явуулах, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, тамхины хяналтын тухай хуулийг иргэд аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчилах ажлын хүрээнд зориулж 620.000 /зургаан зуун хорин мянган/ төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрхи зардлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн хөрөнгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, зориулалтаар гаргахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргыг түр орлон гүйцэтгэгч /П.Мандахбаяр/, нягтлан бодогч /П.Түмэндэлгэр/ нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



ЦАМАРТҮВШИН